



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/186

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулж,
газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэн Баттогтохын Баярмаа /РГ95112600/-ын хүсэлтийг тус тус үндэслэн Мөрөн сумын 7 дугаар баг 29 дүгээр гудамж 09 тоотод байршилтай 6712008561 нэгж талбарын дугаартай 817м², 6712017319 нэгж талбарын дугаартай 681м² гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газруудыг нэгтгэж нийт 1498 м² газрын зориулалтыг үйлчилгээтэй орон сууцны зориулалт бүхий болгон өөрчилж үлдсэн 22 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/361 дүгээр захирамжийн хавсралтын 3 дахь заалт, 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/182 дугаар захирамжийн хавсралтын 4 дэх хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

3. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэн Б.Баярмаатай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН